



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/114

Жаргалант

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралт “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 оны аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, төлөвлөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Д.Шижирмөнх	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	Э.Ононцэцэг	Санхүү албаны дарга
Гишүүдэд	Б.Баярмагнай	БОХ-ын улсын байцаагч
	Б.Сумъяа	Төрийн сангийн мэргэжилтэн
	М.Мөнгөнтуяа	Газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
	О.Банхар	Мал эмнэлгийн тасгийн дарга
	Г.Тэргэл	Нийгмийн бодлогын мэргэжилтэн
	Б.Эрдэнэжаргал	ХАА-н мэргэжилтэн
	Л.Энхдорж	Сан хариуцсан нягтлан бодогч

2.Сумын хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан, Сангийн сайдын 86 тушаалын “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.6-т заасны дагуу хасагдах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ байгаа эсэхийг нягтлан шалгаж багийн Иргэдийн нийтийн хурлаас ирүүлсэн тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээг хэлэлцэн эрэмбэлж хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний жагсаалтыг гаргахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Эрэмбэлсэн жагсаалтыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны дотор Засаг даргад хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Д.Шижирмөнх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

232501280